



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/Ч

Улаанбаатар хот

**Нийслэлийн Онцгой байдлын газрын
эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 104 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/935 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 10,628,580 /арван сая зургаан зуун хорин найман мянга таван зуун ная/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн Онцгой байдлын газар /А.Дашням/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 3 нэр төрлийн 10,628,580 /арван сая зургаан зуун хорин найман мянга таван зуун ная/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Онцгой байдлын газар /А.Дашням/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-т даалгасугай.

ДАРГА




М.БАЯРАА

Тушаал2021

115050000107

Нийслэлийн Өмчийн Ашиглалт Удирдлагын газрын
даргын 2021 оны 3 дугаар сарын 16-өдрийн
11 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Онцгой байдлын газар

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалт анд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХ Х комиссын хурлын
Машин, тоног төхөөрмж										
1	Узелийн сантехникийн байгууламж	1969.01.01	ш	1	525,000	525,000	525,000	-	НИТХТ-ийн 2013 оны 44 дүгээр тогтоол, НЗД-ын 2014 оны А/315 дугаар захирамж, НӨХГ-ын 2014 оны А/382 дугаар тушаалын дагуу 2014 онд гамшгаас хамгаалах Сургалт арга зүйн төвийн барилгыг барих үед нураагдсан.	Устгах
2	Манаачийн байр	1969.01.01	ш	1	804,000	804,000	804,000	-		
3	Сауны байр	1998.01.01	ш	1	9,299,580	9,299,580	9,299,580	-		
						10,628,580	10,628,580			
Үүнээс : Татан төвлөрүүлэх хөрөнгө				3						
Устгах хөрөнгө						10,628,580	10,628,580	-		